ДУНДГОВЬ АЙМАГ
**АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр Дугаар А/70 Тавин

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Төвийн 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ДУГААСЗДТГ/202305 ажлын гүйцэтгэгчээр “Ирмүүн Бармат” ХХК-г сонгон 20,000,000 (Хорин сая) төгрөгийн үнийн дүнгээр гэрээ байгуулсугай.

2. Уг ажлын техникийн тодорхойлолт, ажлыг даалгаврын дагуу гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг “Ирмүүн Бармат” ХХК-ний захирал (Н.Зоригтбаатар)-т даалгасугай.

3. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Ч.Оюунцэцэг), Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Уранцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

**БАТЛАВ**

**ЗАХИАЛАГЧ:**
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА................Ч.УРАНЧИМЭГ

**БАТЛАВ**

**ГҮЙЦЭТГЭГЧ:**
ИРМҮҮН БАРМАТ ХХК-НИЙ
ЗАХИРАЛ
...............Н.ЗОРИГТБААТАР

## “Сумын төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж ” нийлүүлэх ,угсарч суурьлуулах ажлын гэрээ

Дугаар № ДУГААСЗДТГ /202305

2023-06.28 Адаацаг сум

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нэг талаас Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг Даргын Тамгын Газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ИРМҮҮН БАРМАТ ” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу **Худагт цэвэршүүлэх төхөөрөмж нийлүүлэх,угсарч суурьлуулахтай** холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2. Захиалагч нь Адаацаг суманд “**Төвийн 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж** ”нийлүүлэх ,угсарч суурьлуулах ажлыг (цаашид “ажил” гэх) **20,000,000₮ /Хорин сая /** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Гэрээний нийт дүн: 20,000,000 / Хорин сая / төгрөгөөр

1.3. Гүйцэтгэгч нь Адаацаг суманд “**Төвийн 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж** ”нийлүүлэх угсарч суурьлуулах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2023 оны 07 дугаар сарын 07 -ны өдөр хүртэлх хугацаанд тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах ажлыг бүрэн хийж дуусган ашиг лалтад хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч нь гэрээт ажлын хүрээнд тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн дагуу нийлүүлэгдэх болон бусад шаардлагатай ажлуудыг холбогдох стандарт, норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэнэ.

1.4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- Бусад шаардлагатай баримт бичиг;
- Тендер ба үнийн санал
- Техникийн нөхцөл

1.5. Энэхүү гэрээ нь талуудын хоорондын эцсийн тохиролцоо бөгөөд урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалдын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6. Гүйцэтгэгч нь гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн, усны шинж чанараас хамаарч тохиромжтой ,тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн дагуу ажлыг гүйцэтгэх бөгөөд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын явцад орхигдсон сэлбэг хэрэгсэл, хяналтын явцад гарсан зөрчил, гологдолыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.7. Талууд харилцан тохиролцож Цахим худагт шаардлагатай жижиг засвар үйлчилгээг хийлгэж болно.Ажлын даалгаварт тусгасан байх шаардлагатай.

1.8. Гүйцэтгэгч нь тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах үедээ хэрэглэгч байгууллагуудад техник аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч, зохих арга хэмжээг авсан байна.

1.9. Ажлыг захиалагч болон захиалагчийн хяналт хийх эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлнэ. Захиалагч нь сумын ЗДТГ-ын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, гэрээт ажлыг бүрэн хүлээн авсан комиссын актыг үндэслэн 100 хувийг төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

1.10. Ажил гүйцэтгэх хугацааны явцын хяналтыг Захиалагч байгууллага хариуцан гүйцэтгэх бөгөөд ажлын гүйцэтгэл, комиссын актаар баталгаажуулна.

1.11. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.

1.12. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

## ХОЁР. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

2.1. Талуудын аль нэг нь гэрээний үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа зааж, шаардлага тавих бөгөөд үүнийг зөрчсөний улмаас гарсан бодит хохирлыг буруутай тал бүрэн төлж барагдуулна.

2.2. Гүйцэтгэгчийн буруугаас биет байдлын доголдолтой хөренгийг шилжүүлсэн бол уг доголдлыг арилгах үүргийг гүйцэтгэгч тал хүлээнэ.

2.3. Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ энэ гэрээнд заасан хугацаандаа гүйцэтгээгүй, өөрийн удирдлага зохион байгуулалттай холбоотой үүссэн эрсдэл зэргээс шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй гэж захиалагч тал үзвэл үл маргах нөхцөлтэйгээр гэрээг цуцлаж болно.

2.4. Гүйцэтгэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ энэ гэрээнд заасан хугацаанд зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд захиалагч нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих, мэдээлэх эрх бүхий байгууллагад гүйцэтгэгчийг бүртгүүлэх саналыг хүргүүлнэ.

## ГУРАВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

3.1. Талууд харилцан тохиролцож гэрээнд лт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.2. Гэрээний аль нэг тал нь дангаараа гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхгүй бөгөөд ийнхүү үйлдсэн баримт бичгийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

3.3. Энэхүү гэрээний аль нэг заалт хууль тогтоомжид харшилсан болон хууль зөрчсөнд тооцогдсон нь гэрээний бусад зүйл заалтын хүчин төгөлдөр үйлчлэх явдалд нөлөөлөхгүй ба гэрээний бусад заалт хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

3.4. Гэрээний аль нэг тал нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа гэрээт ажлын хугацаа дуусахаас 5 хоногийн өмнө бичгээр ирүүлэх бөгөөд энэ нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.

## ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

4.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

4.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан, тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

## ТАВ. ГЭРЭЭТ АЖЛЫН ХУГАЦАА

5.1. Гэрээт ажлын хугацаа нь 2023 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны оны 07. дугаар сарын .07.-ны өдөр буюу захиалагчид ажлыг хүлээлгэн өгөх хүртэлх хугацаа байна.

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

**6.1.** **Захиалагч:** Дундговь аймгийн Адаацаг сум

**6.2.** **Ашиглагч**: Сумын Засаг даргын тамгын газар

**6.3.** **Гэрээний нэр дугаар: "төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж " нийлүүлэх, угсарч суурьлуулах ажил /ДУГААСЗДТГ/202305**

**6.4.** **Ажил эхлэх өдөр:** 2023 оны 07 дугаар сарын 02-ний өдөр

**6.5.** **Ажлыг хүлээн авах:** Адаацаг сум ЗДТГ

**6.6.** **Гэрээний бичиг баримтууд нь:** Монгол хэл дээр байна.

**6.7.** **Гэрээнд :** Монгол улсын хуулийг хэрэглэнэ.

**6.8.** **Ажил дуусахаар төлөвлөсөн өдөр:** 2023 оны 07 дугээр сарын 07

**6.9.** **Чанарын баталгаат хугацаа:** 1 жил, тухайн хугацаанд техникээс шалтгаалсан эвдрэл, гэмтлийг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлана.

**6.10.** **Төлбөр хийх хугацаа:** Гэрээнд заагдсан ажлыг 100 хувь, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж,цэвэршүүлэх төхөөрөмж тавьсны дараа усны дээжийг Дундговь аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн сорилтын итгэмжлэгдсэн лаборторид шинжлүүлж хариу гарсны дараа ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэгч байгууллагын дансанд шилжүүлнэ./**Цэвэршүүлэгч тавьсны дараах усны шинжилгээний төлбөр гэрээний дүнд багтсан болно./**

**6.11.** Энэхүү гэрээний баримт бичигт заасан гэрээний үнэд үнийн тохируулга /гэрээний үнэд өөрчлөлт/ хийхгүй.

**6.12.** **Алданги ногдуулах хэмжээ:**. Гэрээт хугацаа гүйцэтгэгчээс шалтгаалан хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцно.

Захиалагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг Төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын шийдвэрээс шалтгаалснаас бусад тохиолдолд шилжүүлээгүй бол хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцож гүйцэтгэгч талд төлнө.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| Адаацаг сумын ЗДТГазрын дарга | “Ирмүүн бармат” ХХК ныг төлөөлж: |
| Б.Уранцэцэг | захирал Н.Зоригтбаатар |
| Утас: 99817252 | Утас: 88113890,70087009 |
| | Хаяг УБ ,БЗД 13-р хороо 14-р хороолол |
| | Барилгын Мега төв 1 давхар 109 тоот |

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

2023 ОНЫ САРЫН ӨДӨР

АДААЦАГ СУМЫН УНДНЫ УСНЫ ХУДАГТ УС ЗӨӨЛРҮҮЛЭХ ,ЦЭНГЭГЖҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ СУУРЬЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР,ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| | Тоног төхөөрөмж | Тавигдах шаардлага | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхий шаардлага | Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуучлалын газрын даргын баталсан ажлын даалгаварт тавигдсан шаардлага хангасан байх | заалт | 8 |
| 2 | Мэргэжлийн шаардлага зөвшөөрөл | -Ус зөөлрүүлэх ,цэвэршүүлэх төхөөрөмжийг сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглах / тухайн худгийн усны чанар байдлаас хамаарч төхөөрөмжийг зөв сонгох/<br>- Хэрэглэгчдэд ашиглахад хялбар төвөггүй байх<br>- Ус хангамж шугам сүлжээ,тэдгээрийн тоног төхөөрөмж угсралт,усны барилга байгууламж барих,сэргээн засварлах,шинэчлэх эрхтэй ,зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна.<br>-Инженер техникийн үндсэн ажилтантай байх | | |
| 3 | Урьдчилсан шүүлтүүр | 5 микрон хүртэлх нүдэнд үл үзэгдэх механик хог хаягдал ,шавар,элс ,зэв,наалдамхай бодис тоосонцор гэх мэтийг шүүх | ком | 2 |
| 4 | Ус нөөцлөх сав | УМХЕГ-аас баталсан лаборторийн шинжилгээний бичигтэй байх, бактер үрждэггүй 20 жилээс дээш ашиглах боломжтой байх- /1-1,5 тн багтаамжтай,мэдрэгч хөвүүртэй байх/ | ш | 2 |
| 5 | Ус зөөлрүүлэгч төхөөрөмж | 1 цагт 3000т3 хүртэл усыг зөөлрүүлэх хүчин чадалтай, Төхөөрөмжийн дотор байдаг бодис буюу катионет нь кальци,магни,төмөр ус төрөгчийг зайлуулдаг байх | ком | 2 |
| 6 | Эцсийн шатны шүүлтүүр | Цагт 5000 л ус боловсруулах хүчин чадалтай,ажлын даралт 0,6 Мра аас багагүй байх,усан сан дах зэв органик бодис,коллойд ,элс шавар ,нүдэнд үл үзэгдэх тоосонцор ,хлор хүнд металыг шүүх ,хүний биед зохимжтой эрүүл цэнгэг ,эрдэст ,шүлтлэг усыг боловсруулах, Өөрөө өөрийгөө угааж цэвэрлэдэг байх | ком | 2 |
| 7 | Халаагуур | Халаагуур /үг төхөөрөөмж нь -40 градусаас +35 градус цельсд тасралтгүй ажиллах боломжтой байх,нэмэлт халаагуур,ус дамжих шугам хоолойн дулаалга шийдэж өгөх/ | ш | 1 |
| 8 | Насос | Цэвэр усны зориулалттай ,зэвэрдэггүй ган насос | ш | 2 |
| 9 | Бусад /Холбох | Усанд зэвэрдэггүй ган холболт болон хуванцар | Ком | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгсэл / | материалтай хоолой | | |
| 9 | Төсөв | 20,0 сая төгрөг ОНХсангийн хөрөнгөөр хийгдэх | | |
| 10 | Баталгаат хугацаа | 2 жил /шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийж өгөх/ | сар | 12 |
| 11 | Нэмэлт ажил | Смарт карт тавьсан 2 худгийн жижиг засвар үйлчилгээнүүдийг хийх /плат тогтоогчийг солих,гадаа 1 гэрэл солих,усны шүүрийг цэвэрлэх гм/ | | |
| 12 | Ашиглалтанд хүлээлгэн өгөх | -Ажлын гүйцэтгэгчийг захиалагч талаас томилогдсон ажлын хэсэг гэрээнд заасан хугацаанд газар дээр нь очиж шалган үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авна.<br>-Дундговь аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн сорилтын итгэмжлэгдсэн лабортори шүүсэн усны дээжийг шинжлүүлж эрүүл ахуйн байцаагчийн дүгнэлт гаргуулж хүлээлгэн өгөх | хоног | Ажлын 5 |
| 13 | Захиалгчийн санал | Аюулгүй ажиллагаа ашиглалтын самбар Төхөөрөмжийн ажиллах горим ,цэвэрлэгээ шүүгч шүүлтүүр солих хугацаа,гүйцэтгэгчийн нэр хаяг утас зэрэг мэдээллийг агуулсан зөвлөмжтэй самбарыг худагт байрлуулна. | ш | 2 |

БОЛОВСРУУЛСАН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ч.ОЮУНЦЭЦЭГ

ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр Дугаар А/72 Тавин

Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих
ажлыг хүлээн авах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Төвийн 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Оюунцэцэг (Засаг даргын орлогч)
Гишүүд: Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)
Ч.Урантуяа (Тамгын газрын Нярав)
Ө.Уранбилэг (Нягтлан бодогч)
Л.Бадамханд (Дунд сургуулийн Сургалтын менежер)

2. Дээрх ажлыг актаар хүлээн авч, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ

## АЖИЛХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН АКТ

2023.07.05 Дугаар № Адаацаг сум

Нэг.

1.1 Гэрээний нэр, дугаар, огноо: ДУГААСЗДТГ\202305

1.2 Барааны нэр, хүчин чадал: **"Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих"**

1.3 Захиалагч байгууллага: Адаацаг сумын ЗДТГ

1.4 Гүйцэтгэгч байгууллага: "Ирмүүн бармат " ХХК

1.5 Сумын Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А\72 тоот захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ""**Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих"** ажлыг хүлээн авах томилогдсон.

1.6 Сумын Засаг даргын 2023 оны 7 сарын 05 ны А/72 захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй **"Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих"** хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ДУГААСЗДТГ\202305 тоот гэрээний дагуу нийлүүлэх бараа материалыг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, болон холбогдох баримтуудтай газар дээр нь танилцаж шалган үзэв.Ундны усны эхний шинжилгээг ШУ-ы академи газар зүйн хүрээлэнгээр хийлгэж усны шинж чанарт тохирсон төхөөрөмжийг суурьлуулсан .Ус зөөлрүүлэгч,2 төрлийн шүүлтүүр,ус нөөцлөх сав суурьлуулсан байна.

1.7 **" Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих** ажлыг 2023 оны 07 дугаар сарын 02 нд эхлүүлж 7 сарын 5 ны өдөр бүрэн хүлээлгэж өглөө.

Хоёр.

2.1 **" Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих "** ажлыг үзэж гүйцэтгэгч байгууллага нь гэрээний дагуу ажлаа чанартай сайн гүйцэтгэсэн байна гэж үзлээ.

2.2 Гэрээний дагуу хүлээн авсан ажлыг захиалагч ЗДТГ-ын мэдэлд бүрэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн..

2.3 " **Сумын төвийн 2 худагт цэвэршүүлэгч төхөөрөмж тавих** ажлыг хүлээн авах авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 4 үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч зэрэг холбогдох байгууллагад хувийг хүргүүлнэ.

Хүлээн авсан комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга Ч.Оюунцэцэг
Гишүүд Ж.Батжаргал
Ч.Урантуяа
Ө.Уранбилэг
Л.Бадамханд

Хүлээлгэн өгсөн инженер БААСАНЖАВ С.Баасанжав

## Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: "Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага......ЗДТГазар............

........

Албан тушаал......Нягтлан бодогч............

Овог нэр, О. Уранчимэг

Утасны дугаар......95935345............

Комиссын гишүүний санал:......цэвэршүүлэх 3 янзын шүүлтүүр тавьсан холбогдох ... шаардлага хангасан байсан............

..................

..................

..................

..................

Шийдвэрлэсэн нь:......Эрүүл ахуйн үүргээ бүрэн биелүүлсэн байсан учир хүлээн авахад татгалзах зүйлгүй............

..................

..................

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар:......байхгүй............

..................

..................

..................

Комиссын гишүүн ......О. Уранчимэг....../ /

**Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас**

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: "Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага: ЗДТГазар

Албан тушаал: Сумын засаг даргын орлогч

Овог нэр, Утасны дугаар: Чулуун Оюунцэцэг 92031494

Комиссын гишүүний санал: Худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавьсан. Ашиглалтад орж, ус хэрэглэгчид [illegible] давхар [illegible].
Тоног төхөөрөмжийг [illegible] [illegible] сургалтад [illegible].

Шийдвэрлэсэн нь: Ажлыг хүлээж авахад татгалзах зүйлгүй.

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар:

Комиссын гишүүн: Оюун /Оюунцэцэг/

## Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: "Сургуулийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих" ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага: Адаацаг сумын дунд сургууль

Албан тушаал: Сургалтын менежер

Овог нэр, Лхам Базархан

Утасны дугаар: 99982553.

Комиссын гишүүний санал:

Сургуулийн худагт сургуулийн сурагчдын хэрэгцээ болон иргэдийн хэрэгцээг зориулан ус цэвэршүүлэх төхөөрөмж хийж тавьсан. Манай иргэдийн болон бусад хэрэгцээг усаа хангах зорилгоор хүнсний ус мөн эрүүл баталгаатай хэрэглэх шийдэл болсон.

Шийдвэрлэсэн нь:

Төхөөрөмжийг суурилуулан хүлээн авав.

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар:

Комиссын гишүүн ......................................../ Л.Базархан /

**“Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас**

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: “Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага: Адаацаг сум ЗДТГ

Албан тушаал: 1-р багийн засаг дарга

Овог нэр: Ж. Батжаргал

Утасны дугаар: 88474104

Комиссын гишүүний санал: Цэвэршүүлэх 3 янзын шүүлтүүр тавьсан, холболтууд хийгдэж цэгцлэгдээд хашаасан байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийг биелүүлсэн учир хүлээж аваад ашиглалтад оруулах зүйлтэй.

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар: байхгүй

Комиссын гишүүн ............ /Ж. Батжаргал/

## “Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: “Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага: ЗӨ тасаг

Албан тушаал: нягтлан бодогч Ө

Овог нэр, Ө Урангуа

Утасны дугаар: 95735345

Комиссын гишүүний санал: Цэвэршүүлэх 3 янзын шүүлтүүр тавьсан байсан / холболтууд [illegible] шаардлага хангасан байсан

Шийдвэрлэсэн нь: [illegible] үүргээ биелүүлсэн байсан. [illegible] хүлээн авах татгалзах зүйлгүй

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар: байхгүй

Комиссын гишүүн Ө. Урангуа / /

**“Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажлыг хүлээж авах комиссын гишүүний саналын хуудас**

2023 оны 07 сарын 05 өдөр

Ажлын нэр байршил: “Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажил

Комиссын гишүүний ажилладаг байгууллага: ЗДТГ

1

Албан тушаал: Нярав

Овог нэр: Цэндорж овогтой Урантуяа

Утасны дугаар: 96032670

Комиссын гишүүний санал:

Шаардлага хангасан тул хүлээн авахад татгалзах зүйлгүй

Шийдвэрлэсэн нь:

Гэрээний нөхцлийн дагуу сайн хийж гүйцэтгэсэн байна

Комисс ажиллах боломжгүй гэсэн тайлбар:

Комиссын гишүүн: Урантуяа / Урантуяа